



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өгийнуур сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/65/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Х.Алтанчимэг Цахим хаяг: Altanchimegkh@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	
1.Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгин тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	9
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар

1.Аудитын дүгнэлт



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ᠠᠷᠠᠨᠭᠠᠢ ᠲᠠᠭᠤᠨ № ᠑5
танай _____ -ны № _____ -т

□ АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ □

ӨГИЙНУУР СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГА Б.БАДАМХАНД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өгийнуур сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Өгийнуур сумын соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,153,600.00	6,072,800.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,153,600.00	6,072,800.00
354	Хангамжийн материал	6,153,600.00	6,072,800.00
35410	Бичиг хэргийн материал	323,500.00	242,700.00
35420	Аж ахуйн материал	5,830,100.00	5,830,100.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	70,019,674.46	69,068,514.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	70,019,674.46	69,068,514.01
392	Биет хөрөнгө	63,663,674.46	62,772,514.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	48,740,537.82	48,740,537.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(10,831,230.72)	(16,246,846.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	18,108,755.00	26,055,305.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,026,638.08)	(14,390,824.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,379,187.00	8,379,187.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,038,461.06)	(6,601,969.30)
39214	Бусад үндсэн хөрөнгө	374,000.00	374,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(374,000.00)	(374,000.00)
39217	Ном	16,331,524.50	16,837,124.50
393	Биет бус хөрөнгө	6,356,000.00	6,296,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(60,000.00)	(120,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,116,000.00	6,116,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	76,173,274.46	75,141,314.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	76,173,274.46	75,141,314.01
51	Засгийн газрын хувь оролцоо	76,173,274.46	75,141,314.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	167,082,291.70	167,082,291.70
51101	Өмч: - төрийн	167,082,291.70	167,082,291.70
512	Хуримтлагдсан үр дүн	(100,545,559.95)	(101,577,520.40)
51210	Өмнөх үеийн үр дүн	(100,545,559.95)	(100,545,559.95)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(1,031,960.45)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,636,542.71	9,636,542.71
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	76,173,274.46	75,141,314.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	85,602,420.00	95,329,250.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,836,620.00	8,452,150.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	8,452,150.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		8,452,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	81,765,800.00	86,877,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	81,765,800.00	86,877,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,765,800.00	86,877,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	88,051,864.04	96,361,210.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,051,864.04	96,361,210.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,105,502.04	95,097,358.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,453,984.00	64,515,799.90

Өгийнуур сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	55,453,984.00	64,515,799.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,033,538.00	8,348,957.00
210201	Тэтгэврийн даатгал	4,807,306.00	5,773,456.52
210202	Тэтгэмжийн даатгал	557,288.00	644,994.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	444,830.00	515,987.33
210204	Ажилгүйдлийн даатгал	110,041.00	124,536.50
210205	Эрүүл мэндийн даатгал	1,114,073.00	1,289,982.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,322,030.00	9,799,775.00
210301	Гэрэл, цахилгаан	1,397,030.00	1,011,075.00
210302	Түлш, халаалт	7,825,000.00	8,766,700.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	22,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,373,520.00	816,120.00
210401	Бичиг хэрэг	391,830.00	273,300.00
210402	Тээвэр, шатахуун	433,390.00	353,520.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	478,300.00	119,300.00
2105	Нормативт зардал	-	49,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	100,000.00
210604	Урсгал засвар	-	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	709,396.00	2,064,396.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	554,000.00	1,829,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	75,396.00	155,396.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,213,034.04	9,403,310.45
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,213,034.04	9,403,310.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,946,362.00	1,263,852.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,000.00	858,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.00	858,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,886,362.00	405,852.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,886,362.00	405,852.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(2,449,444.04)</u>	<u>(1,031,960.45)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(2,449,444.04)</u>	<u>(1,031,960.45)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх	167,082,291.70	9,636,542.71	(100,545,559.95)	76,173,274.46
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх	167,082,291.70	9,636,542.71	(100,545,559.95)	76,173,274.46
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	167,082,291.70	9,636,542.71	(100,545,559.95)	76,173,274.46
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,031,960.45)	(1,031,960.45)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх	167,082,291.70	9,636,542.71	(101,577,520.40)	75,141,314.01

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Өгийнуур сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	82,934,400.00	86,877,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	81,765,800.00	86,877,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	81,765,800.00	86,877,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	81,765,800.00	86,877,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	80,513,800.00	86,877,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,513,800.00	86,877,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	73,567,438.00	86,033,247.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	55,453,984.00	64,515,799.90
210101	Үндсэн цалин	55,453,984.00	64,515,799.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,033,538.00	8,348,957.00
210201	Тэтгэврийн даатгал	4,807,306.00	5,773,456.52
210202	Тэтгэмжийн даатгал	557,288.00	644,994.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	444,830.00	515,987.33
210204	Ажилгүйдлийн даатгал	110,041.00	124,536.50
210205	Эрүүл мэндийн даатгал	1,114,073.00	1,289,982.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,782,630.00	9,799,775.00
210301	Гэрэл, цахилгаан	1,315,392.00	1,011,075.00
210302	Түлш, халаалт	7,367,238.00	8,766,700.00
210303	Цэвэр, бохир ус	100,000.00	22,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	516,840.00	529,600.00
210401	Бичиг хэрэг	66,500.00	66,500.00
210402	Тээвэр, шатахуун	206,740.00	207,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	70,000.00
210404	Ном, хэвлэл	54,300.00	66,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.00	119,300.00
2105	Нормативт зардал	49,000.00	49,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.00	49,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	100,000.00
2107	Томилолт, зочны зардал	53,550.00	50,920.00
210702	Дотоод албан томилолт	53,550.00	50,920.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,577,896.00	2,639,196.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,422,500.00	2,421,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.00	80,000.00
210807	Газрын төлбөр	75,396.00	137,396.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,946,362.00	843,852.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,000.00	438,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000.00	438,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,886,362.00	405,852.10
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,886,362.00	405,852.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
-----	----------	------------	-----------	-------	------

Өгийнуур сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,877,100.0	86,471,247.9	405,852.1	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,877,100.0	86,471,247.9	405,852.1	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,438,300.0	86,033,247.9	405,052.1	99.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	64,529,400.0	64,515,799.9	13,600.1	100.0
210101	Үндсэн цалин	64,529,400.0	64,515,799.9	13,600.1	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,711,500.0	8,348,957.0	362,543.0	95.8
210201	Тэтгэврийн даатгал	6,130,300.0	5,773,456.5	356,843.5	94.2
210202	Тэтгэмжийн даатгал	645,300.0	644,994.6	305.4	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	516,200.0	515,987.3	212.7	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	129,100.0	124,536.5	4,563.5	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	1,290,600.0	1,289,982.1	617.9	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,800,000.0	9,799,775.0	225.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,700,000.0	1,011,075.0	688,925.0	59.5
210302	Түлш, халаалт	8,000,000.0	8,766,700.0	(766,700.0)	109.6
210303	Цэвэр, бохир ус	100,000.0	22,000.0	78,000.0	22.0
2104	Хангамж, бараа материалын зардал	529,900.0	529,600.0	300.0	99.9
210401	Бичиг хэрэг	66,500.0	66,500.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	207,800.0	207,800.0	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.0	70,000.0	-	100.0
210404	Ном, хэвлэл	66,300.0	66,000.0	300.0	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	119,300.0	119,300.0	-	100.0
2105	Нормативт зардал	49,000.0	49,000.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	49,000.0	49,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.0	100,000.0	-	100.0
210604	Урсгал засвар	100,000.0	100,000.0	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	70,500.0	50,920.0	19,580.0	72.2
210702	Дотоод албан томилолт	70,500.0	50,920.0	19,580.0	72.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,648,000.0	2,639,196.0	8,804.0	99.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,422,500.0	2,421,800.0	700.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	80,000.0	80,000.0	-	100.0
210807	Газрын төлбөр	145,500.0	137,396.0	8,104.0	94.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	438,800.0	438,000.0	800.0	99.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	438,800.0	438,000.0	800.0	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	438,800.0	438,000.0	800.0	99.8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,877,100.0	86,471,247.9	405,852.1	99.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,877,100.0	86,471,247.9	405,852.1	99.5
132001	Орон нутгийн төсвөөс	86,877,100.0	86,471,247.9	405,852.1	99.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	5.0	7.0	(2.0)	140.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	2.0	3.0	(1.0)	150.0
620003	Үйлчлэх ажилтан	2.0	3.0	(1.0)	150.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	5.0	7.0	(2.0)	140.0
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	3.0	4.0	(1.0)	133.3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.0	3.0	(1.0)	150.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Архангай аймгийн Өгийнуур сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Алтанчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өгийнуур сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 6 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өгийнуур сумын Соёлын төв нь соёлын үйлчилгээг хөдөөгийн хүн амд хүргэн соёлын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, үндэсний болон орчин үеийн соёл урлагийн үйл ажиллагааг ард иргэд, хүүхэд багачуудад зааж сургах, түгээн дэлгэрүүлэх чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа орон нутгийн төсвийн байгууллага байна.

Тус байгууллага нь тайлант онд “Сумын нийт хүн амд соёл урлаг, чөлөөт цаг олон нийтийн бүх үйл ажиллагааг иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн зохион явуулна гэсэн зорилготой” зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өгийнуур сумын соёлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 86.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 0.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн шатны ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1.0 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	6.1	6.1	0	-
Үндсэн хөрөнгө	70	69.1	0.9	0.01
Нийт хөрөнгө	76.1	75.1	1	0.01
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	76.1	75.1	1	0.01
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	76.1	75.1	1	0.01

Бараа материал эхний үлдэгдлээс өөрчлөгдөөгүй байна.

Бараа материалын данс нь 6.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 9.9 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 9.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 6.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 0.9 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 70.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 8.4 сая төгрөгийн хөрөнгийг хандиваар нэмэгдсэн бол тайлант хугацаанд байгуулсан 9.4 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурч 69.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй шууд холбоотой бөгөөд тайлант хугацаанд 1.0 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	81.7	86.9	5.2

Нэмэлт санхүүжилтийн орлого			0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3.8	8.4	4.6
Үйл ажиллагааны орлого	85.5	95.3	9.8
Бараа үйлчилгээний зардал	81.1	95.1	14
Урсгал шилжүүлэг	6.9	1.2	-5.7
Үйл ажиллагааны зардал	88.0	96.3	8.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2.5	-1	1.5

Өгийнуур сумын соёлын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 9.8 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 139.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 53.0 сая төгрөгөөр бууруулж нийт зардлыг 86.8 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Төсвийн төслийг өндөрөөр хийсэн нь их засварын зардлыг 20.0 сая төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 15.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд улсын төсвөөс 86.8 сая төгрөгөөр санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 86.4 сая төгрөг зарцуулан 0.4 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлсэн шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлуудыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Соёлын төв нь 2021 онд Ковид-19 цар тахлын үеийн дэглэм, улс, аймаг, сумын онцгой комиссоос гаргасан соёл урлагийн үйлчилгээг хориглосон шийдвэрийн улмаас олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зохион байгуулаагүй байна. Өөрөөр хэлбэл өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлгүй ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2021 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэлэхэд Үүнд:

- Тайлант жилд урсгал зардлаас 0.4 сая төгрөгийн хэмнэлт гаргаж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь батлагдсан төсвийн 2.8 хувийг эзэлж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өгийнуур сумын соёлын төв нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайланд онд Монгол улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд батлагдсан төсвөөс 0.4 сая төгрөгийг төвлөрүүлэн 2.8 хувийг хэмнэж, 7.2 хувийн буюу 1.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.
2. Цалин тогтоосон тушаал шийдвэрийг тулган шалгахад 2021.10.01-нээс галч, 2021.03.01-ээс бүжгийн багшийн 2 орон тоо нэмэгдэж нийт 9.2 сая төгрөгийн цалин олгосон нь ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43-р тогтоолын 1.2 “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн

ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4.1.3 дахь заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийцлийн аудитын асуудалтай холбоотой илэрсэн зөрчлөөс өөрөөр алдаа зөрчил илрээгүй болно.

Залруулагдаагүй алдаа зөрчил илрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт хүргүүллээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Өгийнуур сумын Соёлын төв										
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Өгийнуур сумын Соёлын төв	3	10.6					2	10.6	1	
НИЙТ ДҮН		3	10.6					2	10.6	1	